



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар A16317

Хэрлэн сум

**Хэнтий аймгийн Санхүүгийн
хяналт, дотоод аудитын албанд дэмжлэг
үзүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн байгууллага иргэдээс тавьсан хүсэлтийг шийдвэрлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ